

ДОРНОГОВЬ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/56/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор: Л.Равдандорж

Утас: 70523020 Цахим хаяг: ravdandorj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.06

№ 1-6/39

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт орсон бөгөөд тодруулбал төсвийн хөрөнгөөр 20.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, Улсын ерөнхий прокурорын газраас 35.9 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч ашиглагдахгүй байгаа илүүдэлтэй 10.0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлсэн байна. Мөн үндсэн хөрөнгийг 24.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн дахин үнэлж, 6.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Аудитын гол асуудал

Прокурорын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.6-д зааснаар хөдөлмөрийн чадвараа алдсан албан хаагчдын цалин хөлсний зөрүүг тооцож олгохдоо холбогдох тооцооллыг хавсаргаагүй, бүртгэл хөтлөөгүйгээс 0.6 сая төгрөгийн цалин илүү, 0.1 сая төгрөгийн цалин дутуу олгосон мөн бараа материалын тайлан хөтлөөгүй, эд хөрөнгийн тооллогыг эд хариуцаг бүрээр гаргаж баталгаажуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

019079347

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>41,203,424.97</u>	<u>38,132,174.97</u>
33	АВЛАГА	6,831,304.55	6,804,754.55
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	6,831,304.55	6,804,754.55
35	БАРАА МАТЕРИАЛ	34,372,120.42	31,327,420.42
354	Хангамжийн материал	34,372,120.42	31,327,420.42
35410	Бичиг хэргийн материал	5,741,500.00	3,932,700.00
35420	Аж ахуйн материал	18,561,340.00	19,333,040.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,693,260.00	3,693,260.00
35440	Түлц, шатах тослох материал	2,390,020.42	224,020.42
35470	Бусад хангамжийн материал	3,986,000.00	4,144,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>470,667,770.26</u>	<u>514,650,843.71</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	470,667,770.26	514,650,843.71
392	Биет хөрөнгө	451,190,770.26	480,173,843.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	342,784,630.00	342,784,630.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-20,855,914.20	-28,134,885.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,900,000.00	42,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-71,233,333.40	-11,750,000.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	98,755,073.09	137,973,523.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,500,619.44	-35,700,398.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,684,325.81	68,697,649.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,572,674.59	-35,833,457.77
39214	Бусад үндсэн хөрөнгө	925,000.00	925,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-695,717.01	-788,216.97
393	Биет бус хөрөнгө	19,477,000.00	34,477,000.00
39301	Программ хангамж	917,500.00	917,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-917,500.00	-917,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,477,000.00	34,477,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>511,871,195.23</u>	<u>552,783,018.68</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>511,871,195.23</u>	<u>552,783,018.68</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	511,871,195.23	552,783,018.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	330,858,920.10	345,858,920.10
51101	Өмч: - төрийн	330,858,920.10	345,858,920.10
512	Хуримтлагдсан үр дүн	69,154,402.83	95,066,226.28
51210	Өмнөх үеийн үр дүн	69,154,402.83	69,154,402.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	25,911,823.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	111,857,872.30	111,857,872.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>511,871,195.23</u>	<u>552,783,018.68</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	827,657,488.00	775,156,494.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,056,688.00	60,262,694.00
120	Нийтлэг татварын бус орлого	86,056,688.00	60,262,694.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	86,056,688.00	60,262,694.00

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	86,056,688.00	60,262,694.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	741,600,800.00	714,893,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	736,565,800.00	714,893,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	736,565,800.00	714,893,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,035,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	721,026,167.15	740,134,920.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	721,026,167.15	740,134,920.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	608,555,186.63	634,768,183.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	422,954,587.72	461,918,922.29
210101	Үндсэн цалин	290,494,560.15	286,271,168.04
210102	Нэмэгдэл	129,210,027.57	136,225,831.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,250,000.00	20,426,283.64
210104	Урамшуулал	00.00	18,995,639.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,853,498.94	58,001,341.33
210201	Тэтгэврийн даатгал	35,608,998.94	39,544,232.35
210202	Тэтгэмжийн даатгал	4,561,100.00	4,654,080.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,648,900.00	3,723,344.28
210204	Ажилгүйдлийн даатгал	912,200.00	916,343.98
210205	Эрүүл мэндийн даатгал	9,122,300.00	9,163,340.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,922,781.32	18,391,645.00
210301	Гэрэл, цахилгаан	2,923,826.32	2,743,717.00
210302	Түлш, халаалт	12,370,600.00	12,600,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,628,355.00	3,047,928.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,303,996.00	27,079,734.00
210401	Бичиг хэрэг	13,749,235.00	11,777,100.00
210402	Тээвэр, шатахуун	6,420,000.00	7,855,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,247,531.00	3,150,614.00
210404	Ном, хэвлэл	3,040,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	950,000.00	950,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,897,230.00	3,346,000.00
2105	Норматив зардал	00.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,703,836.00	6,212,310.00
210604	Урсгал засвар	17,703,836.00	6,212,310.00
2107	Томилолт, зочны зардал	1,205,000.00	2,574,000.00
210702	Дотоод албан томилолт	1,205,000.00	2,574,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,639,653.00	3,057,570.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,520,000.00	2,850,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	690,775.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,770.00	125,770.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	54,000.00	54,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	231,000.00	00.00
210807	Газрын төлбөр	18,108.00	27,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,971,833.65	56,032,660.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,862,790.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,000,000.00	10,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,971,833.65	42,169,870.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,470,980.52	105,366,737.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,140,500.00	2,260,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,640,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	2,260,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	97,330,480.52	103,106,737.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,330,480.52	103,106,737.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>106,631,320.85</u>	<u>35,021,573.42</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	9,109,749.97
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	9,109,749.97
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-9,109,749.97
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>106,631,320.85</u>	<u>25,911,823.45</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>742,282,863.50</u>	<u>714,920,350.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	682,063.50	26,550.00
120	Нийтлэг татварын бус орлого	682,063.50	26,550.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	682,063.50	26,550.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	682,063.50	26,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	741,600,800.00	714,893,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	736,565,800.00	714,893,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	736,565,800.00	714,893,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,035,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>706,497,663.50</u>	<u>694,920,350.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	706,497,663.50	694,920,350.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	594,026,682.98	589,553,612.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	422,954,587.72	461,918,922.29
210101	Үндсэн цалин	290,494,560.15	286,271,168.04
210102	Нэмэгдэл	129,210,027.57	136,225,831.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,250,000.00	20,426,283.64
210104	Урамшуулал	00.00	18,995,639.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,853,498.94	58,001,341.33
210201	Тэтгэврийн даатгал	35,608,998.94	39,544,232.35

210202	Тэтгэмжийн даатгал	4,561,100.00	4,654,080.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,648,900.00	3,723,344.28
210204	Ажилгүйдлийн даатгал	912,200.00	916,343.98
210205	Эрүүл мэндийн даатгал	9,122,300.00	9,163,340.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,922,781.32	18,391,645.00
210301	Гэрэл, цахилгаан	2,923,826.32	2,743,717.00
210302	Түлш, халаалт	12,370,600.00	12,600,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,628,355.00	3,047,928.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,773,066.00	21,466,494.00
210401	Бичиг хэрэг	11,349,495.00	8,798,300.00
210402	Тээвэр, шатахуун	4,740,000.00	5,689,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,284,031.00	3,150,614.00
210404	Ном, хэвлэл	5,353,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	950,000.00	950,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,096,540.00	2,877,560.00
2105	Норматив зардал	00.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,143,096.00	6,171,460.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	250,000.00	00.00
210604	Урсгал засвар	23,893,096.00	6,171,460.00
2107	Томилолт, зочны зардал	1,205,000.00	2,574,000.00
210702	Дотоод албан томилолт	1,205,000.00	2,574,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,584,653.00	3,817,570.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,465,000.00	3,610,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	690,775.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,770.00	125,770.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	54,000.00	54,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	231,000.00	00.00
210807	Газрын төлбөр	18,108.00	27,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,590,000.00	15,712,180.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,590,000.00	5,712,180.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,000,000.00	10,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,470,980.52	105,366,737.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,140,500.00	2,260,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,640,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	2,260,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	97,330,480.52	103,106,737.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,330,480.52	103,106,737.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>35,785,200.00</u>	<u>20,000,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>35,785,200.00</u>	<u>20,000,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>35,785,200.00</u>	<u>20,000,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>35,785,200.00</u>	<u>20,000,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,785,200.00	20,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-35,785,200.00</u>	<u>-20,000,000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-р үлдэгдэл	311,381,920.10	94,843,940.55	32,466,347.03	438,692,207.68
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	311,381,920.10	94,843,940.55	32,466,347.03	438,692,207.68
C07	Тайлант үеийн үр дүн	19,072,000.00	00.00	-110,345,312.15	-91,273,312.15
C08	2021 оны 12-р сарын 31-р үлдэгдэл	330,858,920.10	111,857,872.30	69,154,402.83	511,871,195.23
D01	2021 оны 12-р сарын 31-р үлдэгдэл	330,858,920.10	111,857,872.30	69,154,402.83	511,871,195.23
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	330,858,920.10	111,857,872.30	69,154,402.83	511,871,195.23
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	15,000,000.00	00.00	00.00	15,000,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	25,911,823.45	25,911,823.45
D09	2012 оны 12-р сарын 31-р үлдэгдэл	345,858,920.10	111,857,872.30	95,066,226.28	552,783,018.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү дүн	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	714,893,800.00	714,920,350.00	-26,550.00	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	714,893,800.00	714,920,350.00	-26,550.00	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	712,633,800.00	609,553,612.62	103,080,187.38	85.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	538,324,300.00	461,918,922.29	76,405,377.71	85.81
210101	Үндсэн цалин	290,136,400.00	286,271,168.04	3,865,231.96	98.67
210102	Нэмэгдэл	207,545,900.00	136,225,831.55	71,320,068.45	65.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,984,000.00	20,426,283.64	7,557,716.36	72.99
210104	Урамшуулал	12,658,000.00	18,995,639.06	-6,337,639.06	150.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,290,500.00	58,001,341.33	9,289,158.67	86.20
210201	Тэтгэврийн даатгал	45,994,400.00	39,544,232.35	6,450,167.65	85.98
210202	Тэтгэмжийн даатгал	5,324,000.00	4,654,080.23	669,919.77	87.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,259,200.00	3,723,344.28	535,855.72	87.42
210204	Ажилгүйдлийн даатгал	1,064,800.00	916,343.98	148,456.02	86.06
210205	Эрүүл мэндийн даатгал	10,648,100.00	9,163,340.49	1,484,759.51	86.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,677,000.00	18,391,645.00	285,355.00	98.47
210301	Гэрэл, цахилгаан	2,850,800.00	2,743,717.00	107,083.00	96.24
210302	Түлш, халаалт	12,796,000.00	12,600,000.00	196,000.00	98.47
210303	Цэвэр, бохир ус	3,030,200.00	3,047,928.00	-17,728.00	100.59
2104	Хангамж, бараа материалын зардал	21,487,000.00	21,466,494.00	20,506.00	99.90
210401	Бичиг хэрэг	8,799,000.00	8,798,300.00	700.00	99.99
210402	Тээвэр, шатахуун	5,699,500.00	5,689,520.00	9,980.00	99.82
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,077,500.00	3,150,614.00	-73,114.00	102.38

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	951,000.00	950,500.00	500.00	99.95
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,960,000.00	2,877,560.00	82,440.00	97.21
2105	Нормативт зардал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,193,000.00	26,171,460.00	21,540.00	99.92
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.00
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	6,193,000.00	6,171,460.00	21,540.00	99.65
2107	Томилолт, зочны зардал	3,268,000.00	2,574,000.00	694,000.00	78.76
210702	Дотоод албан томилолт	3,268,000.00	2,574,000.00	694,000.00	78.76
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,881,600.00	3,817,570.00	8,064,030.00	32.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,674,000.00	3,610,000.00	8,064,000.00	30.92
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,800.00	125,770.00	30.00	99.98
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	54,000.00	54,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	27,800.00	27,800.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24012400.00	15712180.00	8,300,220.00	65.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,012,400.00	5,712,180.00	3,300,220.00	63.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,000,000.00	10,000,000.00	5,000,000.00	66.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2260000.00	2260000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,260,000.00	2,260,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,260,000.00	2,260,000.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	714,893,800.00	714,920,350.00	-26,550.00	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	714,893,800.00	714,893,800.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	714,893,800.00	714,893,800.00	0.00	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	26,550.00	-26,550.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	26,550.00	-26,550.00	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	21.00	21.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20.00	20.00	0.00	100.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	08.00	08.00	0.00	100.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	03.00	03.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	09.00	09.00	0.00	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Прокурорын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Зөрчлийн хэрэгт хяналт тавих:
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих:
- Төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох:
- Зөрчил хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох:
- Эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох:
- Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах:
- Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд хяналт тавих:

Байгууллагын үйл ажиллагааны зорилт

- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагааны чанар үр дүнг дээшлүүлэх:
- Улсын яллагчийн мэтгэлцэх ур чадварыг сайжруулах:
- Эрх зүйн хэлбэрт дүгнэлт хийх ажлыг хэвшүүлэх:
- Прокурор ажилтнуудын компьютер дээр ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх:
- Шалгалт судалгааны чанар үр дүнг сайжруулъя:
- Гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлье:
- Прокурор ажилчдын сахилга хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагыг өөрчлөх, төлөвшүүлэх:

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар Байгууллагын үйл ажиллагаанд нийтлэг хэрэглэгддэг дараах хууль тогтоомжууд байна. Үүнд:

- *Төсвийн тухай хууль*
- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль*
- *Зөрчлийн тухай хууль*
- *Эрүүгийн тухай хууль*
- *Иргэний хууль*
- *Зөрчлийн хэрэг бүртгэлд хяналт тавих, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих, зөрчил хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох зэрэг журам болон бусад эрх зүйн баримт бичиг байна.*

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй үзлээ. Тус байгууллагад дотоод аудитын нэгж болон дотоод аудиторын орон тооны ажилтан байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Улсын ерөнхий прокурорын 2021 оны А/179 тушаалаар батлагдсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40.9 сая төгрөгөөр буюу 8 хувиар *өссөн* байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	34,372.1	31,327.4	(3,044.7)
Үндсэн хөрөнгө	470,667.8	514,650.8	43,983.1
Нийт хөрөнгө	511,871.2	552,783.0	40,911.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	330,858.9	345,858.9	15,000.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	511,871.2	552,783.0	40,911.8

Дээрх хүснэгтээс харахад, үндсэн хөрөнгө, нийт хөрөнгө, засгийн газрын хувь /Эздийн өмч/, өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн өмнөх оноос 40.9 сая төгрөг буюу 8 хувиар өссөн байна. Энэ нь Улсын ерөнхий прокурорын газраас үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө шилжин ирсэн, албаны конторын газрыг бүртгэлд авсан, үндсэн хөрөнгө бэлтгэсэн тэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 636.7 сая төгрөг, зарлагыг 636.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 25.8 зардлыг сая төгрөгөөр нэмэгдүүлж, 662.5 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 10.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 714.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 0.03 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 714.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 0.03 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 611.8 сая төгрөг буюу 85.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 99.6 сая, байцаан шийтгэх ажиллагааны зардлыг 3.5 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 714.9 сая төгрөг буюу 100 хувьтай байгаа нь орон нутгийн төсвөөс 33.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосонтой холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	706,533.8	606,943.6	99,590.2	85.9
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал	2,260.0	2,260.0	-	100.0
3	Байцаан шийтгэх ажиллагаа	6,100.0	2,610.0	3,490.0	42.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд нэмэлт санхүүжилтийн дансаар ажил гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорноговь аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Л.Равдандорж гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2022оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1/100 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 693.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль *хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын цалин хөлс болон бусад нэмэгдэл урамшуулал, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.*

Энэ хуулийн хүрээнд цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 76.4 сая, дотоод албан томилолтоос 0.7 сая, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 8.0 сая, бусад бараа үйлчилгээний зардлаас 8.3 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны системд нийт 149 мэдээллийг мэдээлэхээс 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй зарлагын 4 гүйлгээг хугацаа хоцроож, бусад мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 2.3 сая төгрөгийн албан хаагч нарт олгосон мөнгөн тэтгэмжийг шууд зардлаар бүртгэж тооцооны дансаар дамжуулаагүй алдааг аудитын явцад залруулж, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 14.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс 14.7 сая төгрөгийн алдааг залруулж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	0	0.0	0	0.0	0
Албан шаардлага	0	0.0	0	0.0	0
Зөвлөмж	1	0.0	1	0.0	100
Нийт дүн	1	0.0	1	0.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 2.9 сая төгрөгийн алдааг залруулсан. Үүнд: Албан хаагчдад олгосон 2.3 сая төгрөгийн тэтгэмжийг шууд зардлаар бүртгэж тооцооны дансаар дамжуулаагүй мөн холбогдох тооцооллыг алдаатай хийж 0.6 сая төгрөгийг илүү олгосон байсныг залруулсан.

Аудитаар нийт 3.0 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 0.1 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 5 зөвлөмж өгсөн.

5.2 Албан шаардлага

1. МУЕП-оос прокурорын албан хаагчдыг томилж цалин хөлс нэмэгдэл урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож олгохыг төсвийн шууд захирагч нарт даалгасан боловч цалин хөлс, нэмэгдэл тогтоосон тушаал шийдвэр гаргаагүй байна
2. Ажилчдын цалинд үүссэн зөрүүг бодохдоо холбогдох тооцооллыг хавсаргаагүй байна.
3. Цалинд үүссэн зөрүүг олгохдоо алдаатай тооцоолж 2 албан хаагчид 0.1 сая төгрөг дутуу олгосон байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин бодолттой холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн тооцооллыг бүрэн хийгээгүйгээс шалтгаалж ажилтанд үүссэн өглөг, авлагыг данс бүртгэлт үнэн зөв тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3.6-тай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин бодолт, тооцоололтой холбоотой үүссэн өглөг, авлагыг данс бүртгэлд бүрэн тусгах.

Илрүүлэлт: ТҮ албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг олгохдоо журамд заасан хувь хэмжээгээр үнэлээгүй бүх ажилтанд 25 хувиар олгосон байна. Энэ нь Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн садын 1996 оны 63/104 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4,5,7 дугаар заалтад тусгагдсантай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Ур чадварын нэмэгдлийг олгоходоо холбогдох журам, аргачлалын дагуу үнэлж байх.

Илрүүлэлт: Шилжүүлэн ажиллаж байгаа прокуроруудын цалингийн тооцооллыг хийгээгүй байна. Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 2.8-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажлаас чөлөөлөгдсөн, шилжүүлсэн албан хаагчдын цалингийн тооцоог бүрэн дуусгаж байх.

2. Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын тайлан гаргаагүй, программын бүртгэлээр санхүүгийн тайланд нэгтгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэгжүүлэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 9-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох заавар, аргачлалын дагуу тайлан мэдээг бүрэн гаргаж байх.

Илрүүлэлт: Эд хөрөнгийн тооллогыг хийхдээ эд хариуцагч бүрээр карт хөтлөөгүй, гарын үсэг зураалж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.2-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн тооллогыг эд хариуцагч бүрээр хийж эд хөрөнгийн карт хөтлөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

дааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын 5 албан хаагчид олгосон шагнал, тэтгэмжийг шууд зардлаар бүртгэсэн байна	1	2,260.0			1	2,260.0	1	2,260.0				
ХЧТА прокуроруудын цалингийн зөрүүг алдаатай тооцоолж илүү цалин олгосон байна.	1	638.3	1	638.3			1	638.3				
Дүн	1	2,898.3	1	638.3	1	2,260.0	1	2,898.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлагатай тооцуулах албан		Хууль, хяналтын байгуул		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтн	Тоо	Дүн	
Цалингийн тооцооллыг бүрэн хийгээгүйгээс шалтгаалж ажилтанд үүссэн өглөг, авлагыг данс бүртгэлт тусгаж ажиллаагүй байна	1	-						1	-				
ТҮ албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг олгохдоо журамд заасан хувь хэмжээгээр үнэлээгүй бүх ажилтанд 25 хувиар олгосон байна.	1	-						1	-				
МУЕП-оос прокурорын албан хаагчдыг томилж цалин хөлс нэмэгдэл урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож олгохыг төсвийн шууд захирагч нарт даалгасан боловч цалин хөлс, нэмэгдэл тогтоосон тушаал шийдвэр гаргаагүй байна	1	-			1	-							
Ажилчдын цалинд үүссэн зөрүүг бодохдоо холбогдох тооцооллыг хавсаргаагүй байна.	1	-			1	-							
Шилжүүлэн ажиллаж байгаа прокуроруудын цалингийн тооцооллыг хийгээгүй байна	1	-						1	-				
Албан хаагчдын цалинд үүссэн зөрүүг олгохдоо алдаатай тооцоолж дутуу цалин олгосон байна	1	88.6			1	88.6							
Бараа материалын тайлан гаргаагүй, программын бүртгэлээр санхүүгийн тайланд нэгтгэсэн байна.	1	-						1	-				
Эд хөрөнгийн тооллогыг хийхдээ эд хариуцагч бүрээр карт хөтлөөгүй, гарын үсэг зураалж баталгаажуулаагүй байна	1	-						1	-				
Дүн	8	88.6			3	88.6		5	-				